35.8. Барааг ТОӨЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.

35.9. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоо захиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэх олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

**36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.

36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТОӨЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 18.2–т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

36.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

**37. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах**

37.1. **Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.**

## Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

**38. Гэрээ байгуулах эрх олгохшалгуур**

38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.6-д заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

38.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож,

тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.

**39. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**

39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.

39.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх барааны төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

39.3. Захиалагч засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ:

**(1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;**
**(2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;**
**(3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;**
**(4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;**
**(5) Тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.**

39.4. Тендер нь шалгарсан оролцогч ТОӨЗ-ын 42 дугаар зүйлийн дагуу гаргасан гүйцэтгэлийн баталгаа болон гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсний дараагаар захиалагч ТОӨЗ-ын 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож байгаа тухай шалгараагүй бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

**40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх**

40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.

**41. Гэрээнд гарын үсэг зурах**

41.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

41.2. **Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа**ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТОӨЗ-ны 39.2-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

**42. Гүйцэтгэлийн баталгаа**

42.1. Гүйцэтгэлийн баталгааггэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.

42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.

42.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах эм, эмнэлгийн хэрэгсэл талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

| **ТОӨЗ-ны холбогдох заалт** | **А. Ерөнхий зүйл** |
|---|---|
| **ТОӨЗ 1.1** | Захиалагч нь: ***Увс аймгийн Нэгдсэн Эмнэлэг*** |
| **ТОӨЗ 1.1** | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: **УВСЭМ -2021/01001** |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 1.2** | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Үүнд: Захиалагчийн багцууд:1-38<br><br>*2-р багц* *Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмүүд*<br><br>*3-р багц* *Тархины цусан хангамжийн хямрал болон үрэвслийн эсрэг өвчин намдаах эмүүд*<br><br>*4-р багц* *Зүрх судас болон,даралт бууруулах эмүүд*<br><br>*5-р багц* *Элэг ,цөс хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн эмүүд*<br><br>*6-р багц* *Даавар болон спазмолик төрөх эмэгтэйчүүдийн чиглэлийн эмүүд*<br>*7-р багц* *Сийвэн орлох цусанд нөлөөлөх эмүүд*<br>*8-р багц* *Антибиотик*<br><br>*10-багц* *Витамин эрдэс бодис болон бусад тарилгууд*<br><br>*13-багц* *Харшилын тосон түрхэц*<br><br>*16-рбагц* *Боолтын материал болон бусад*<br><br>*18-рбагц* *Эх барихын цомог болон бусад*<br><br>*21-багц* *Иммунологийн шинжилгээний урвалж*<br><br>*24-рбагц* *Гематологийн шинжилгээний урвалж*<br><br>*29-багц* *Биоспи, Цитологи, Гистологи лабораторид хэрэглэх уусмал* |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Улсын төсөв*** |
| | **Б. Тендерийн баримт бичиг** |
| **ТОӨЗ 8.1** | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:<br>***Увс аймгийн Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг 3 давхар 311 тоот өрөө***<br>***Утас;70453658 ,99458449*** |
| **ТОӨЗ 8.1** | Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын **5 хоногоос багагүй байна.** |
| | **В. Тендер бэлтгэх** |
| **ТОӨЗ 11.1** | Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэл дээр байна. Үүнд: ***Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, хамтран ажиллах гэрээ зэрэг нотлох бариймтыг Монгол хэл рүү баталгаат орчуулгаар орчуулан ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 12.1 (а) – (ё)** | 12.1 (а) - (ё)-д заасан баримт бичгээс гадна дараах материалыг нэмж бүрдүүлнэ :<br>***1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.***<br>***2. Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар , Харилцагч банкны тодорхойлолтуудыг тус тус ирүүлнэ.***<br>***3. Эмийн бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх.***<br>***4. Тухайн багцад хамаарах Тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд: Монгол Улсын эрүүл мэндийн сайдын :***<br>***ХХ-Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн ханган нийлүүлэх, импортлох, худалдах***<br>***МХХ- Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис ханган нийлүүлэх импортлох***<br>***ТХ-Эмнэлгийн багаж тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез ханган нийлүүлэх , импортлох, худалдах***<br>***АХ-Ахуйн шавьж , мэрэгч устгах , халдваргүйжүүлэх үйлчилгээний тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлтэй байна.***<br>***5.Нийлүүлэх эм эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн каталоги ирүүлнэ. Хэрэв гадаад хэл дээр бол баталгаат орчуулгаар Монгол хэлрүү орчуулсан байна.***<br>***6.Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь ТОӨЗ 18.3 дахь үзүүлэлт тус бүрийг хангасан байх ба өөрийн гүйцэтгэх ажлын үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.***<br>***7. Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн санал бараа нийлүүлэтийн хуваарийг баталгаажуулан , техникийн болон ажиллагааны дэлгэрэнгүй тодорхойлолт, техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл заалт бүрээр нотлон харуулсан тайлбартай ирүүлнэ.***<br>***8. Тендерт гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл ирүүлэх***<br>***9. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай албан тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлэх***<br>***10. Татвар, нийгмийн даатгал болон харилцагч банкнаас тодорхойлолт авахад*** |

| | |
|---|---|
| | ***татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлэх***<br>***Дээрхи шаардлагатай мэдээллийг ирүүлээгүй тохиолдолд тендерийн үнэлгээнд харгалзан үзнэ.***<br>Жишиг заалт<br>Тендерт оролцогч нь үндсэн үйлдвэрлэгч биш бол үндсэн үйлдвэрлэгчийн бараа нь чанарын стандартыг хангасан бөгөөд захиалсан тооны барааг үйлдвэрлэх чадвартайг баталсан баталгааг харуулах шаардлагатай. "Үндсэн үйлдвэрлэгч"-гэж эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэж тодорхой тунгийн дагуу хэлбэржүүлэх, савлах, хаяглах болон чанарын шинжилгээ хийдэг үйлдвэрлэгчийг хэлнэ. Тендерт оролцогч нь үйлдвэрлэгчийн орны зохицуулагч эрх бүхий этгээдээс эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх эрхийг баталгаажуулсан гэрчилгээг хавсаргасан байна. |
| **ТОӨЗ 14.1** | Хувилбарт тендер ирүүлэхийг***"зөвшөөрөхгүй"*** |
| **ТОӨЗ 15.5** | Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: ***"Incoterms 2010"].*** |
| **ТОӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)** | Бараа хүргэгдэх газар: ***Увс аймгийн Нэгдсэн Эмнэлэгт хүргэх*** |
| **ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)** | "Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)": ***Увс аймгийн Эрүүл мэндийн газрын агуулах, Нэгдсэн эмнэлгийн эмийн сан*** |
| **ТОӨЗ 15.9 (б) (1)** | Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIP үнээс гадна дараах үнээр санал болгож болно . Үүнд: ***Нийлүүлэх эм хэрэгслийн үнэд НӨАТ, тээврийн зардал, гаалийн татвар , даатгал болон бусад зардал бүгд багтсан байна.*** |
| **ТОӨЗ 15.10** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад ***"тохируулахгүй тогтмол байна.*** |
| **ТОӨЗ 16.1** | Тендерийн валют: ***Төгрөг байна.*** |
| **ТОӨЗ 18.1 (а)** | Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: ***"шаардлагатай"*** |
| **ТОӨЗ 18.1 (б)** | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: ***2018, 2019 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 18.1 (г)** | Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: ***2018, 2019 онуудын аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн борлуулалтын орлогын дүн нь санал болгож буй үнийн 50 хувиас багагүй байна. Нотлох баримтыг хавсаргана. Үүнд: Гаалийн бүрдүүлэлт, татварын тайлан, гэрээний хуулбар гэх мэт...*** |
| **ТОӨЗ 18.1 (д)** | Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: ***"шаардлагагүй"*** |
| **ТОӨЗ 18.2 (а)** | Борлуулалтын хэмжээ: ***Сүүлийн 2 жил 2018, 2019онуудын борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50-иас багагүй.*** |
| **ТОӨЗ 18.2 (б)** | Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: ***2018 ,2019он.*** |
| **ТОӨЗ 18.2** | Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: |

| | |
|---|---|
| **(в)** | ***шаардлагатай. Хөргөгч, дулаалгатай зориулалтын тээврийн хэрэгсэл. Холбогдох гэрчилгээ, нотлох баримтыг ирүүлнэ. Өөрийн биш тохиолдолд түрээсийн гэрээг ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 18.2 (г)** | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: ***Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг нотлох баримт ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 18.2 (д)** | Ашигтай ажилласан байх жилийн тоо: ***2018 , 2019 онуудад ашигтай ажилласан байна.*** |
| **ТОӨЗ 18.2** | Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт:<br>Дараах баримт бичгүүдийг тендерт заавал хавсаргана.<br>*Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэхэд дараах нөхцөл байдлыг нотлох баримт бичиг шаардагдана:*<br>*(i) Хэрэв тендерт оролцогч нь гэрээний дагуу өөрийн үйлдвэрлэсэн барааг нийлүүлж буй бол:*<br>(а) тендерт оролцогч нь бараа үйлдвэрлэгдсэн улсад үйл ажиллагаа явуулдаг;<br>(б) тухайн орны эрх бүхий байгууллагаас тухайн барааг нийлүүлэх эрхийг авсныг;<br>(в) тендерийн баримт бичигт заагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг 2-оос доошгүй жил, ижил төрлийн барааг 2-аас доошгүй жил үйлдвэрлэж, борлуулсныг;<br>(г) **ДЭМБ-ын GMP-ийн сертификат эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсад худалдаанд гаргах эрхийг тухайн орны зохицуулах эрх бүхий этгээдээс авсан, эсхүл PIC-ийн гишүүн орны эрх бүхий этгээдээр баталгаажсан бөгөөд тендер ирүүлэх хүртэлх сүүлийн 2 жилд чанарын стандартын шалгалт хийгдсэнийг;**<br>*(ii) Хэрэв тендерт оролцогч нь нийлүүлж буй бараагаа өөрөө үйлдвэрлэгүй бол,*<br>(а)**Тендерт оролцогч нь барааг нийлүүлэх зөвшөөрлийг үйлдвэрлэгч эсхүл гэрээт борлуулалгчаас албан ёсоор авсан буюу Монгол улсад тухайн барааг нийлүүлэх шалгууруудыг хангасныг;**<br>**(б)Шаардлагатай бол GDP (Good Distribution Practice)-ийн сертификат авсныг**<br>Тендерт оролцогч нь дараах нэмэлт мэдээллийг хавсаргана:<br>(а) Үйлдвэрлэлийн хүчин чадлын мэдээлэл;<br>(б) Сүүлийн 2 жилийн аудитаар хянагдсан санхүүгийн тайлангийн хуулбар;<br>(в) Байгууллага дээр хийгдсэн чанарын хяналтын үнэлгээ , үйлчилгээний үзүүлэлтийн талаарх мэдээлэл<br>(г) Сүүлийн 3 жилд хийгдсэн томоохон нийлүүлэлтийн жагсаалт;<br>(д) **Тендерт оролцогчийн үйлдвэрлэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гэрчилгээний хамт /Тусгай зөвшөөрлийн дугаар, огноо/;**<br>**(е) ДЭМБ-ын журмын дагуу барааны нэр төрөл тус бүрд авсан эм, эмнэлгийн хэрэгслийн сертификат.** |
| **ТОӨЗ 18.4** | Дотоодын давуу эрхийн зөрүү: ***"тооцно "***<br>***Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлтийг ирүүлэх бөгөөд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 103 дугаар тогтоол , Сангийн сайдын 2007 оны тушаалаар баталсан "Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал"-ын нөхцөлүүдийг хангаж буйг нотлох*** |

| | |
|---|---|
| | ***бариймтыг тендерийн бүрэлдэхүүнд тусгай хэсэг болгон ирүүлнэ.*** |
| **ТОӨЗ 20.1** | Тендер нээснээс хойш ***45*** хоногийн туршид хүчинтэй байна. |
| **ТОӨЗ 21** | **Тендерийн баталгааны үнийн дүн: багц бүрт 1%**<br>**Үүнд: Хүчинтэй байх хугацаа:** ***2021 оны 03 сарын сар 28ны өдрийг хүртэл хүчинтэй байна.*** |
| **ТОӨЗ 22.1** | Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: ***1 хувь*** |
| | **Г. Тендер ирүүлэх** |
| **ТОӨЗ 23.3 (б)** | Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:<br>Тендер хүлээн авах этгээд: ***Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн алба /Утас-7045-3658, 95107557 /***<br>Байгууллагын хаяг: ***Увс аймаг Улаангом сум Нэгдсэн Эмнэлэг 3 давхар***<br>Давхар болон өрөөний дугаар: ***3 давхар санхүүгийн алба***<br>Аймаг, хот: ***Увс аймаг, Улаангом сум 3-р баг***<br>Шуудангийн дугаар: ***Увс аймаг Улаангом сум, Нэгдсэн Эмнэлэг***<br>Улс: ***Монгол Улс*** |
| **ТОӨЗ 23.3 (в)** | Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ:<br>Нэр: ***Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх***<br>Тендер шалгаруулалтын дугаар: **УВНЭ -2021 /01**001 |
| **ТОӨЗ 24.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: 2021 оны 02 дүгээр сарын 26-***ний өдөр***<br>Цаг: ***9цаг 00 минут*** |
| | **Д. Тендерийг нээх, үнэлэх** |
| **ТОӨЗ 28.1** | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:<br>Байшин,гудамжнынэр: ***Увс аймаг Улаангом сум 3-р баг,*** Давхар болон өрөөний дугаар: ***3-р давхар 311 тоот өрөө***<br>Аймаг, хот: ***Увс аймаг, Улаангом сум, 3-р баг***<br>Шуудангийн дугаар: Увс аймгийн Нэгдсэн Эмнэлэг<br>Улс: ***Монгол Улс***<br>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:<br>Огноо: ***2021 оны 02 дүгээр сарын 26-ний өдөр***<br>Цаг: ***10цаг 00 минут*** |
| **ТОӨЗ 35.4** | Санал болгож байгаа багцуудад 35.4-д заасан шалгуурыг хэрхэн хангаж байгаа талаарх мэдээлэл, нотлох баримтыг ирүүлнэ.<br>Нийлүүлэх Эм, эмнэлэгийн хэрэгслийн нэр Чанарын үзүүлэлт<br>35.4.1 35.4. 35.4.3 35.4.4 35.4.5 35.4.6 |

| | |
|---|---|
| | 2 |
| | **Е. Гэрээ байгуулах эрх олгох** |
| | **Шаардлагад нийцсэн хамгийн сайн үнэлэгдсэн тендерт хуулийн хугацаанд гэрээ байгуулах эрх олгоно.**<br>**Гэрээ байгуулагдсан үед захиалагч барааны тоо хэмжээг бууруулах хамгийн их хувь-10%**<br>**Нийлүүлэгч барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь-10%** |

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

## ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ хэсэг нь ТОӨЗ-ны хэсэг бөгөөд захиалагч ТШӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээг хийхдээ тендерийн маягтанд тусгасан үнийн саналаас гадна ТОӨЗ-ын 35.2 (г)-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж болох бөгөөд ингэхдээ дараах шалгуур болон аргачлалыг ашиглан мөнгөөр илэрхийлж, тендерийн маягтад дурдсан үнэд харгалзан тооцсоны үндсэн дээр тендерийн харьцуулах үнийг гаргана. Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

**[Захиалагч тухайн тендер шалгаруулалтад аль тохиромжтой гэж үзсэн үнэлгээний шалгуур, аргачлалуудаас сонгож хэрэглэх нь зүйтэй]**

*(а) Бараа нийлүүлэлтийн хуваарь:* ***["Ашиглана".]***

Тухайн тендер шалгаруулалтанд холбогдох гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь нийлүүлэлтийн хуваарь **(Хавсралт 1)-т** / багцууд нийлүүлэлтийн хуваарь/ заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал бүхий тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Барааг хуваарьт зааснаас ***[Хавсралт 1]*** илүү хоног, сараар хоцроож хүргэхийг санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэн уг тендерээс татгалзана.

*(б) Төлбөрийн хуваарийн зөрүү.* ***[Ашиглана ]***

Тендерт оролцогч ГТН-д заасан төлбөрийн хуваарь (Төлбөрийн нөхцөл)-ийн дагуу үнийг ирүүлнэ. Тендерийг үнэлэхдээ энэхүү төлбөрийн хуваарийг үндэслэнэ. Төлбөрийн хуваариас зөрүүтэй ирүүлсэн саналыг үнэлэхдээ эрт төлбөр авснаар олж болох хүүгийн орлогыг жилийн 15 хувийн хүүгээр тооцож, зөрүүтэй хоногийн тоогоор үржүүлж, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлж үнэлнэ.

*(е) Тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны үр ашиг болон үйл ажиллагааны баталгаа:* ***[ "ашиглахгүй".]***

***[дараах шалгуурын аль нэгийг сонго]***

ТШӨХ-ийн 35.2 (г)-дтусгайлан заасан бол тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны ашиглалтын нийт хугацаанд шаардагдах нэмэлт зардлын дүнг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ. Үнэлгээний тохируулгыг санал болгож буй барааны үйл ажиллагаа буюу үр ашгийн баталгааны доод түвшинд түшиглэн ТШӨХ-ийн **35.2** (г)-д заасан аргачлалын дагуу хийнэ.

1. Тендерт оролцогч санал болгож буй бараандаа техникийн тодорхойлолтод нийцсэн үйл ажиллагаа, үр ашиг болон ашиглалтын баталгаа гаргана. Санал болгосон бараа нь техникийн тодорхойлолтод заасан ашиглалт, үйл ажиллагааны баталгааны доод түвшинг (эсхүл зарим тохиолдолд дээд түвшинг) хангасан тохиолдолд шаардлагад нийцсэн гэж үзнэ. Энэ доод түвшинг (эсхүл зарим тохиолдолд дээд түвшинг) хангаагүй бараа санал болгосон тендерээс татгалзана.
2. Техникийн тодорхойлолтод заасан ашиглалт, үйл ажиллагааны баталгааны доод түвшингээс дутсан (эсхүл илүү гарсан) зөрүүг үнэлгээнд харгалзах зорилгоор

дутагдал (эсхүл илүүдэл) бүрт тохируулах итгэлцүүр[1] тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

**Эсхүл**

ТШӨХ-ийн 35.2 (г)-дтусгайлан заасан бол тендерийн дагуу санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны үр ашгийн байдлыг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ.
Үнэлгээний тохируулгыг хийхдээ техникийн тодорхойлолтонд заасан хамгийн бага үнэ цэнийг харгалзан үзэж санал болгосон барааны бодит бүтээмжийн нэгжид оногдох үнэд түшиглэн, ТШӨХ-ийн 35.2(г)-д заасан аргачлалыг мөрдлөгө болгоно.

(ё) *Барааны дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардал:* ***["ашиглана"]***
Монгол Улсын гаднаас санал болгох барааны орох боомтоос захиалагчийн агуулах хүртэл, эсхүл Монгол Улсын дотроос санал болгох бараг үйлдвэрлэгчээс захиалагчийн агуулах хүртэл дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардлыг үнэлгээний зорилгоор тендерийн EXW, CIF, CIP, эсхүл FOB үнэ дээр нэмнэ.

(ж) *Тусгайлсан* нэмэлт шалгуур
Хуулийн 28.4 дэх хэсэгт заасныг үндэслэн энэхүү тендерийн үнэлгээнд ашиглах бусад нэмэлт шалгуур үзүүлэлт болон түүний аргачлалыг энэ хэсэгт оруулж болно.

**Олон багцтай тендерийг үнэлэх**

ТОӨЗ-ны 35.6-д **з**аасны дагуу захиалагч нэг ба түүнээс дээш багцаар гэрээ байгуулах эрхтэй бол олон багцыг үнэлж гэрээ байгуулах эрх олгоход дараах аргачлалыг мөрдөнө.

Захиалагч багцуудын хамгийн сайн үнэлэгдсэн буюу хамгийн үр ашигтай байх хувилбарыгдараах байдлаар сонгоно. Үүнд:

(а) ТОӨЗ-ны 15.8-д зааснаар багц тус бүрт байх барааны нэр төрөл болон нэр төрөл тус бүрийн тоо хэмжээ нь бүрэн бол тухайн багцад үнэлгээ хийнэ. Тухайн багцад 100 хувь санал ирүүлнэ.

(б) Үнэлгээнд дараах журмыг баримтална:

(i) багц тус бүрт үнэлгээний шалгуурыг хангасан хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тогтоох;
(ii) тендерт оролцогчийн тухайн хамгийн сайн үнэлэгдсэн тендерт санал болгосон үнийн хөнгөлөлтийг санал болгосон аргачлалын дагуу багц тус бүрт тооцох;

(iii) эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байххувилбараар гэрээ байгуулах эрх олгохоор сонгох. Ингэхдээ нэг тендерт оролцогч 2 ба түүнээс дээш багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн бол түүний гэрээг хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаж тогтооно. Хэрвээ тухайн оролцогч 2-оос дээш багцад гэрээ хэрэгжүүлэх чадвар нь хангалтгүй гэж үнэлэгдвэл түүний чадавхид тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

[1] Энэ тайлбарыг тендерийн баримт бичигт үлдээнэ. Тендерийн үнэлгээнд ашиглах тохируулах итгэлцүүр нь техникийн тодорхойлолтын ***[холбогдох зүйлийн дугаарыг бичнэ үү]***-т заасан хэмжээнээс, эсхүл хамгийн сайн ашиглалт, үйл ажиллагааны баталгааны үзүүлэлтийг санал болгосон тендерийн уг хэмжээнээс 1 хувь дутах (илүү гарах) бүрт ***[дүн, тендерийн үнэлгээний валютаар]*** тооцно. Бүхэл хувь хүрэхгүй бол энэ дүнг мөн харьцаагаар бууруулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

**Тендер шалгаруулалтын маягтыг бөглөх санамж**

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендерийн маягт, үнийн хуваарийг бөглөж, энэ бүлэгт заасан маягтаар гаргасан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Арифметик алдаа, хүлээн зөвшөөрөгдөх зөрүү (төлбөрийн хуваарь, барааг хүргэх хуваарь гэх мэт), сэлбэг болон барааны тоо ширхэгийг тендерийн баримт бичгийн дагуу залруулж, өөрчилсний дараа гэрээний маягтад гарын үсэг зурна.

Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

**МАЯГТ №: ТШМ-1**

**ТЕНДЕРИЙН МАЯГТ**

***[огноо]***

***(Захиалагч байгууллагын нэр)***-ын дарга _____танаа

1. Бид, ***[тендерт оролцогчийн нэрийг оруул],*** энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн ***[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]***-г ***[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]*** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.

2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.

3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт ***[үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]*** үзүүлнэ.

4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс ***[тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.

6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

*МАЯГТ №: ТШМ-2А*

***МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН***
**БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(А ангилал)

Огноо:_____
НТШ-ын дугаар: _____
Тендерийн урилгын дугаар: ___
Хувилбарт тендерийн дугаар: _____
Хуудасны ____ -ын _____ дугаар ___

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Тоо ширхэг болон эд анги | EXW нэгж үнэ | Нэр төрөл бүрийн EXWбүгд үнэ (4x5) | Бараг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТОӨЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол) | Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэх хувь | ТОӨЗ-ны 15.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9) |
| | | | | | | | | | |
| **Тендерийн нийт үнэ (10)** | | | | | | | | | |

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МАЯГТ №: ТШМ -2Б

**МОНГОЛУЛСЫНГАДНАҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ БАРААНЫҮНИЙНХУВААРЬ**

Огноо: _____
НТШ-ын дугаар: _____
Тендерийн урилгын дугаар: _____
Хувилбарт тендерийн дугаар: _____

(Б ангилал)

Хуудасны _____ –ын _____

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл № | Бараан ы тодорх ойлолт | Гарал үүслийн улс | Тоо ширхэг | ТОӨЗ-ны 15.9 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ | Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 х 5) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээни й үнэ (хэрэв ТШӨХ, ТОӨЗ-ны 15.9(б).(3)-д шаардсан бол) | ТОӨЗ-ны 15.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8) |
| | | | | | | | | |
| **Тендерийн нийт дүн (9)** | | | | | | | | |

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____

МАЯГТ №: ТШМ -2В

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

Огноо: _____
НТШ-ын дугаар: _____
Тендерийн урилгын дугаар: _____
Хувилбарт тендерийн дугаар: _____
Хуудасны _____ –ын _____

(В ангилал)

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл № | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо | Тоо ширхэг | ТОӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ | ТОӨЗ-ны 15.9 (в).(2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ] | ТОӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7) | ТОӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8х5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ | Бараг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТОӨЗ-ны 15.9 (в) (5)-д шаардсан бол) | Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11) |
| | | | | | | | | | | | |
| **Тендерийн нийт үнэ (12)** | | | | | | | | | | | |

**Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг _____ Огноо _____**

МАЯГТ №: ТМ-3А

# 3. ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
# (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]–ийн[2] төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

(1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;

2. захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

(а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;

(б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;

(в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь ***[огноог оруул]***өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:
Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

МАЯГТ №: ТМ-3Б

[2] Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зєвшєєрєх чєлєєтэй хєрвєх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь тендерт оролцогчдод єгєх зааварчилгааны 21.1-д заасантай ижил байна.

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

*[Тендерт оролцогчийн нэр]* (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн бирж] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]–ийн[3] төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчын засгийн газрын бондыг[4] үндэслэн батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

(2) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;

3. захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

(а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;

(б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;

(в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ.

Энэхүү баталгаа нь ***[огноог оруул]***өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:
Албан тушаал, нэр:

Банк/Биржийн тамга:

Огноо:

Хаяг:

---

[3] Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зєвшєєрєх чєлєєтэй хєрвєх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь тендерт оролцогчдод єгєх зааварчилгааны 21.1-д заасантай ижил байна.

[4] Засгийн газрын бондны эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-с доошгүй сарын дараа байна.

МАЯГТ №: ТМ-4

ҮЙЛДВЭРЛЭГЧ/ГЭРЭЭТ БОРЛУУЛАГЧИЙН ИТГЭМЖЛЭЛ

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна. Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагч ийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. ТШӨ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]
НТШ-ын дугаар: [оруул:тендер шалгаруулалтын дугаар]
Хувилбарын дугаар: [оруул:энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____танаа

Бид, [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]-д байршилтай [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр] нь [оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/ борлуулдаг бөгөөд, үүгээр [оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр] компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан [оруул: барааны нэр ба товч тодорхойлолт], барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 5. Чадварын мэдээлэл ирүүлэх маягтууд

МАЯГТ №: ТМ-5А

**Санал болгож буй туслан гүйцэтгэгч**

| | Зүйл | Туслан гүйцэтгэгчийн нэр | Бүртгэгдсэн газар болон чадавхи |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

МАЯГТ №: ТМ-5Б

**Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага**

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

| | | |
|---|---|---|
| 1. | Гэрээний дугаар | |
| | Гэрээний нэр | |
| | Улсын нэр | |
| 2. | Захиалагчийн нэр | |
| 3. | Захиалагчийн хаяг | |
| 4. | ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог | |
| 5. | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>☐Үндсэн нийлүүлэгч ☐ Туслан гүйцэтгэгч ☐ Түншлэлийн гишүүн | |
| 6. | Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэл дэх хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна)<br>Мөнгөний нэгж Мөнгөний нэгж Мөнгөний нэгж | |
| 7. | Гэрээний дүн: _____; Туслан гүйцэтгэх гэрээ: _____; Түншлэл дэх хувьд ногдох гэрээний дүн: _____; | |
| 8. | Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо | |
| 9. | Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах) | |
| 10. | Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _____ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах) | |
| 11. | Тусгай техникийн шаардлагууд. | |
| 12. | Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн ажлын эзлэх дундаж хувийн жин, тухайн гэрээний уг сурвалжийг тусгах. | |

МАЯГТ №: ТМ-5В

**Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ**

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа | Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

МАЯГТ №: ТМ-5Г

**Санхүүгийн чадавхи**

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албанд тушаасан (Захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

| | | |
|---|---|---|
| Банк | Банкны нэр | |
| | Банкны хаяг | |
| | | |
| | Утас | Холбоо барих ажилтны нэр, албан тушаал |
| | Факс | Телекс |

Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр илэрхийлнэ.

| Санхүүгийн мэдээлэл /ам.доллараар/ | Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд | | | | | Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | 4 | 3 | 2 | 1 | 1 | 2 |
| 1. Нийт хөрөнгө | | | | | | | |
| 2. Эргэлтийн хөрөнгө | | | | | | | |
| 3. Нийт өглөг | | | | | | | |
| 4. Эргэлтийн өглөг | | | | | | | |
| 5. Татварын өмнөх ашиг | | | | | | | |
| 6. Татварын дараах ашиг | | | | | | | |

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

| Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр | Дүн |
|---|---|
| 1. | |
| 2. | |
| 3. | |

ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

| Тендерт оролцогчийн нэр |
|---|

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

| | |
|---|---|
| 1. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 2. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 3. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 4. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |

**Шинэчилсэн үнийн хуваарь**

Шинэчилсэн үнийн хуваарь нь (хэрэв өөрөөр заагаагүй бол) гэрээний нэг хэсэг болох бөгөөд нийлүүлэгчийн ирүүлсэн тендер дэх үнийн хуваариас ялгаатай байвал түүнийг орлоно. Энэ шинэчилсэн үнийн хуваарь нь ТОӨЗ-ны 18.3, 24.2, болон 33.1 дүгээр зүйлд заасны дагуу аливаа залруулга, тохируулгыг тусгана.

МАЯГТ №: ТМ-6

**Эмийн бүтээгдэхүүний сертификатын загвар**
**Эмийн бүтээгдэхүүний сертификат[1]**

ЭнэсертификатньДЭМБ-ынсанал болгосон форматад нийцэж байгаа болно.

Сертификатын дугаар: _____

Экспортлогч (сертификатыг олгосон) улс: _____

Импортлогч (хүлээн авагч) улс:_____

1. Эмийн нэр болон тунгийн хэмжээ :

_____

1.1 Үндсэн үйлчлэгч бодис[2] болон нэгж тунгийн хэмжээ[3].

_____

_____

Бүрэлдэхүүний бүрэн чанарын болон оролцогч бодисын талаар тайлбарыг[4] үзнэ үү.

1.2 Энэхүү бүтээгдэхүүнд импортлогч орны худалдаанд гаргах лиценз олгогдсон уу ?[5] тийм/үгүй

1.3 Энэхүү бүтээгдэхүүн нь экспортлогч орны худалдаанд гардаг уу ? тийм/үгүй/мэдэхгүй

Хэрэв 1.2-т “тийм” хариултыг сонговол 2А-г үргэлжлэн бөглөж 2Б-г алгасах.

Хэрэв 1.2-т “үгүй” хариултыг сонговол 2Б-г үргэлжлэн бөглөж 2А-г алгасах[6]

2А. 1 Бүтээгдэхүүний лицензийн дугаар ба олгосон өдөр:

_____

2А.2 Бүтээгдэхүүний лиценз[7] эзэмшигч (нэр ба хаяг):

_____

_____

2А.3 Бүтээгдэхүүний лиценз эзэмшигчийн статус[8]: а/б/в

2А.3.1 б болон в заалтыг сонгосон бүлгийн үйлдвэрлэгч байгууллагын нэр ба хаяг:[9]

_____

_____

2А.4 Чанарын баталгаажилтын иж бүрдэл тогтолцоотой юу ?[10] тийм/үгүй

2А.5 Бүтээгдэхүүний мэдээлэл нь лицензийн шаардлагыг хангасан уу ?[11] тийм/үгүй/шалгагдаагүй

2А.6 Хэрэв лиценз эзэмшигчээс өөр бол сертификат авах хүсэлт гаргагч (нэр ба хаяг ):[12]

2Б. 1 Сертификат авах хүсэлт гаргагч (нэр ба хаяг ):

2Б.2 Хүсэлт гаргагчийн статус: а/б/в

2Б.2.1 б болон в заалтыг сонгосон бүлгийн үйлдвэрлэгч байгууллагын нэр ба хаяг:[9]

_____

_____

2Б.3 Яагаад худалдаанд гарах эрхгүй вэ ?

Шаардлагагүй/шаардаагүй/төлөвлөж буй/татгалзсан

2Б.4 Тусгай тэмдэглэгээ: [13]

3. Сертификат олгогч эрх бүхий этгээдээс бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч үйлдвэрт тогтсон хугацаанд хяналт шалгалт явагддаг уу ?

тийм/үгүй/бөглөх боломжгүй[14]

Хэрэв шаардлагагүй бол асуулт 4-т шилжих

3.1 Тогтмол хяналтын үе (жил): _____

3.2 Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч үйлдвэр нь шалгагдсан уу ?

тийм/үгүй

3.3 Үйлдвэр болон түүний үйл ажиллагаа нь ДЭМБ-ийн GMP стандартаар баталгаажсан уу ?[15]

тийм/үгүй/бөглөх боломжгүй[16]

4. Сертификат авах хүсэлт гаргагчийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээлэл нь сертификат олгогчийн шаардлагыг хангасан уу ? [11]

тийм/үгүй

Хэрэв үгүй бол шалтгааныг тайлбарлах: _____

_____

Сертификат олгогчийн хаяг: _____

Утасны дугаар: _____ Факсын дугаар: _____

Эрх бүхий этгээдийн нэр:

_____

Гарын үсэг:

_____

Огноо ба тамга:

_____

**<u>Ерөнхий заавар</u>**

**Схемийг мөрдөх болон хүснэгтийг бөглөхөд шаардлагатай бүрэн мэдээллийг гарын авлагаас үзнэ үү.**

**Хүснэгтийг компьютероор бөглөх нь тохиромжтой. Түүнийг гар бичмэлээр бус хэвлэмэл байдлаар бөглөж ирүүлнэ.**

**Шаардлагатай мэдээлэл, тэмдэглэгээг нэмэлт хуудас ашиглан бичиж хавсаргана уу.**

**<u>Тайлбар бичиг</u>**

1. ДЭМБ-аасзөвлөмжболгосонэнэхүүсертификатньэмийнбүтээгдэхүүнболонсертификатаваххүсэлтгаргагчийнстатусыгтодорхойлно. Тухайнбүтээгдэхүүнийтунболонэмийнхэлбэрөөрчлөлтбүрийнхувьдтүүнийүйлдвэрлэлийнаргабатүүндзөвшөөрөлолгосонмэдээлэлялгаатайбайхтулсертификатньзөвхөнтухайннэгбүтээгдэхүүндолгогдоно.
2. Альболохолонулсыннэршилэсхүлүндэснийпатентийнбуснэршлийгхэрэглэх
3. Эмийн хэлбэрт орсон бодисуудын жагсаалтыг сертификат дээр тэмдэглэх буюу хавсаргана.
   1) Бодисуудын тоо хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл оруулах нь сайн боловч бүтээгдэхүүний лиценз эзэмшигчтэй хэрхэн тохиролцсоноос хамаардаг.
   2) Бүтээгдэхүүний лицензээр эмийн борлуулалт, түгээлт, эсхүл хэрэглээний талаар ямар нэгэн хязгаарлалт байгаа бол энэ тухай мэдээллийг хавсаргах
   3) Цаашид 2А ба 2Б хэсгүүдийн аль нэг нь бөглөгдөнө.
   4) Лиценз нь нөхцөлтэйгөөр өгөгдсөн буюу хараахан зөвшөөрөгдөөгүй байгаа бол энэ тухай дурдах
   5) Тухайн этгээд бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхэд ямар үүрэгтэй болохыг тодоройлох:
   (а) эмийг тунгийн хэлбэрээр үйлдвэрлэгч
   (б) үйлдвэрлэгдсэн эмийг тунгийн хэлбэрээр савлаж болон эсхүл хаягладаг
   (в) дээрхийн алинд ч оролцдоггүй
   6) Энэ мэдээлэл нь зөвхөн бүтээгдэхүүний лиценз эзэмшигчийн зөвшөөрлөөр, бүртгэгдээгүй эмийн хувьд өргөдөл гаргагчийн зөвшөөрлөөр өгөгдөнө. Энэ хэсгийг бөглөөгүй бол холбогдох талууд энэ мэдээллийг оруулахаар зөвшилцөлд хүрээгүй гэж үзнэ. Үйлдвэрлэлийн байршлын талаарх мэдээлэл нь бүтээгдэхүүний лицензэд

багтдаг болохыг анхаарах. Хэрэв үйлдвэрлэлийн байршил өөрчлөгдсөн бол лицензэд өөрчлөлт оруулах шаардлагатай эсхүл тэрээр хүчингүйд тооцогдоно.

7) Энэ эмийн лиценз олгосон техник үндэслэлийг нэгтгэн харуулсан үндэсний эмийн зохицуулах албаны гаргасан баримт бичиг байна.
8) Энэ нь үндэсний эмийн зохицуулах албаны баталсан бүтээгдэхүүний шинж чанарын нэгтгэл зэрэг бүтээгдэхүүний мэдээлэлд хамаарна.
9) Энэ тохиолдолд сертификат олгох зөвшөөрлийг бүтээгдэхүүний лиценз эзэмшигчээс авсан байх шаардлагатай
10) Хүсэлт гаргагч бүртгэл шаардахгүй хэлбэрийг сонгосон шалтгааныг заана уу:

(а) эийн бүтээгдэхүүнийг тодорхой нөхцөлд хийгдэх эмчилгээнд зориулж бүтээсэн, тухайлбал экспортлогч оронд өргөн тархаагүй өвчинд зориулсан

(б) халуун орны нөхцөлд тогтвортой байх чанарыг нь нэмэгдүүлэх шаардлагыг харгалзан бүтээгдэхүүнийг өөрчилсөн

(в) импортлогч оронд хэрэглэхийг зөвшөөрөөгүй эмийн туслах бодисыг хасаж бүтээгдэхүүнийг өөрчилсөн

(г) үндсэн үйлчлэгч бодисын ялгаатай хэмжээний дээд хязгаарт нийцүүлэн бүтээгдэхүүнийг өөрчилсөн

(д) бусад шалтгааныг бичих

11) Хамаарахгүй гэдэг нь үйлдвэрлэгч нь сертификат олгох улсад байрладаггүй бөгөөд шалгалт туршилтыг үйлдвэрлэгчийн орны байгууллага гүйцэтгэхийг хэлнэ.
12) Энэ сертификатад орсон эмийн чанарын хяналт, үйлдвэрлэлийн шаардлага нь ДЭМБ-ын эмийн шинжилгээний хорооны 32-дахь тайланд тусгагдсан. ДЭМБ-ын биологийн бүтээгдэхүүний стандартчиллын шинжээчийн хороо нь биологийн бүтээгдэхүүнийг тусгайлан авч үзэхээр зөвлөмж гаргасан.
13) Энэ хэсгийг бүтээгдэхүүний лиценз эзэмшигч эсхүл өргөдөл гаргагч дээрх тайлбар 7-д заасан \б\ эсхүл \в\-д хамаарах тохиолдолд бөглөнө. Ялангуяа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гадаадын этгээд оролцсон тохиолдолд энэ нь маш чухал. Энэ тохиолдолд хүсэлт гаргагч эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шат бүхэнд оролцсон гэрээлэгч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлоход шаардлагатай болон эдгээр талуудад хийгдсэн шалгалтын мөн чанар, хүрээг тогтоох мэдээллийг гаргаж эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШААРДЛАГЫН ХУВААРЬ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШААРДЛАГЫН ХУВААРЬ БЭЛТГЭХ САНАМЖ

Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт бараа тус бүрийн хувьд нийлүүлэгдсэн байх хугацаа болон тухайн нэр төрлийн онцлогийг харуулсан техникийн тодорхойлолттой уялдсан товч тайлбар, тоо хэмжээг оруулна.

Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт эм, эмнэлгийн хэрэгслийн олон улсын нэршил /INN/ эсхүл ерөнхий нэр (холимог эмийн хувьд оролцсон бодис тус бүрийн нэр), бодис тус бүрийн тун (метрийн нэгжээр), нэгж эмийн хэлбэр (шахмал, капсул, тарил/уусмал г.м), боодлын хэмжээ болон тоо ширхэгийг тусгана.

Зарим тохиолдолд нийлүүлэгч нэгж эмийн тоо ижил боловч боодлын хэмжээ өөр бараа санал болгоход харилцан үл ойлголцлоос сэргийлж нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт нэгж болон боодлын нийт дүнг тус бүрт нь шаардаж болно. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт дурдсан боодлын хэмжээг өөрөөр санал болгох боломжтой эсэхийг тусгайлан заах шаардлагатай.

Нийлүүлэлтийн хуваарьт гэрээ байгуулагдсан өдрөөс хойшхи эхний 7 хоногоор хэмжсэн хугацааг заах ба энэ нь бараа нийлүүлэгдсэн байх хугацааг харуулах ба энэ нь EXW нөхцөлийн хувьд захиалагчийн агуулах эсхүл CIP нөхцөлийн хувьд заасан газар хүртлэх хугацаа байна.

| № | Барааны нэр, товч тодорхойлолт | Тун | Тоо хэмжээ | Нийлүүлэлтийн хуваарь (7 хоногоор) | Тээврийн хэрэгслийн хэлбэр |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БЭЛТГЭХ САНАМЖ

Ойлгомжтой тодорхой бичигдсэн техникийн тодоройлолт нь захиалагчийн шаардлагад бодитой нийцсэн тендер боловсруулж өрсөлдөх боломжийг тендерт оролцогчдод олгодог.

Энэ бүлэгт оруулсан жишиг заалт нь гарын авлага, зааварчилгаа болоход зориулагдсан болно. Техникийн тодорхойлолтыг худалдан авах ажиллагаа тус бүрийн онцлогоос хамаарч захиалагч ялгаатайгаар бэлтгэн тухайн тендерийн баримт бичигт тусгах тул энд заасан жишиг заалт, бичвэрийг шууд үгчлэн ашиглах албагүй.

Чадвартай тендерт оролцогчдын дунд нээлттэй тендер шалгаруулалтыг явуулахад техникийн тодорхойлолт нь өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх боломжийг хангасан байдлаар бэлтгэгдэх ёстой.

Техникийн тодорхойлолтод GMP-ийн шаардлагууд, фармакопейн стандарт, нэршил ба бүтээгдэхүүнд тавигдах шаардлага буюу тайлбар, хүчинтэй хугацаа, баглаа боодол болон хаяглах заавартай холбоотой мэдээллийг оруулахаас гадна бүтээгдэхүүний чанарыг илтгэх GMP болон чанарын баталгааны сертификат, түүнчлэн тендерийн хамт, мөн ачилтын явцад ирүүлэх бусад нотлох баримт зэрэгт тавигдах шаардлагуудыг энд тодорхойлсон байдаг.

Зөвхөн ингэж тодорхой зааснаар худалдан авах ажиллагааны хэмнэлт, үр ашиг, шударга байх зорилтууд биелэгдэж, ирсэн тендерүүд шаардлагад нийцэх боломжтой болж, улмаар тендерүүдийг үнэлэхэд тус дөхөм болох юм.

Хэрэв барааны нэр төрөл, багц тус бүрт баглаа боодол, хаяглалтын тусгай шаардлага тавигдах бол түүнийг нийлүүлэлтийн шаардлагын хуваарь хэсэгт заах бөгөөд харин ерөнхий техникийн тодорхойлолтыг харуулсан энэ хэсэгт нийлүүлэгдэх бүх бараанд тавигдах баглаа боодол, хаяглалтын нийтлэг шаардлагуудыг зааж өгнө.

### Техникийн тодорхойлолт

*[Тендерийн баримт бичигт оруулвал зохих техникийн тодорхойлолтыг захиалагч боловсруулж энд бичнэ. Худалдан авах эмийн жишиг техникийн тодорхойлолт болон багцлах жишгийг өргөн хэрэглэгддэг зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөлд үндэслэн хавсаргав.]*

## Эм, эмнэлгийн хэрэгслийн жишиг техникийн тодорхойлолт

**1. Бүтээгдэхүүний болон баглаа боодлын тодорхойлолт**

а. Тендерийн урилгын дагуузахиалагчийн худалдан авах эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эмнэлгийн хэрэгсэл нь зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад орсон байна.
Савлагаа, шошгоны стандарт нь ДЭМБ-ийн эм үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хяналтын дүрэм (GMP)-ийн хамгийн сүүлийн шаардлагуудыг бүрэн хангасан байна. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг нийлүүлэх тендерт оролцогч түүнийг импортлох тусгай зөвшөөрөл авсан байна.

б. Бүтээгдэхүүний тодорхойлолтод эмийн хэлбэр /шахмал, тарил/уусмал болон нунтаг, тосон түрхлэг гэх мэт/ болон найрлага, тун хэмжээ /олон улсын нэгж {IU}, мг, процент)-г заана.

в. Эм, эмнэлгийн хэрэгсэл болон түүний савлалт, хаяглалтын материал нь (шил, хуванцар сав гэх мэт) тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Бүх савлагаа нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, савлах стандартыг хангаж дахин савлах боломжгүйгээр битүүмжлэгдсэн байна. Захиалагч аливаа нэмэлт шаардлагыг тусгайлан тайлбарласан байна.

г. Шошго болон хэрэглэх заавар нь захиалагчийн тусгайлан заасан хэл дээр байна.

д. Хөлдөөх эсхүл тодорхой хэмийг тогтвортой байлгах зэрэг хадгалалтын тусгай горим шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн шошго болон сав, баглаа боодолд үүнийг тусгайлан зааж тээвэрлэлтийн явцад мөрдөнө.

е. Гэрээ байгуулах эрх авсан нийлүүлэгч захиалагч шаардсан тохиолдолд тухайн бүтээгдэхүүний тайлбар зааварчилгааг тендерийн хэл дээр хөрвүүлнэ.

**2. Хаяглах заавар**

2.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн үндсэн савлагаан дээрх шошго нь GMP стандартыг хангасан байх бөгөөд дараах мэдээллийг агуулсан байна:

1) Олон улсын нэр (INN) болон худалдааны нэрийн дээр байнга бичигдэх ерөнхий нэршлийг бичсэн байна. Худалдааны нэр нь ерөнхий нэршлээс илүү тод ба том бичигдэх ёсгүй;
2) Эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);
3) үндсэн үйлчлэгч бодис, түүний нэгж тун дахь хэмжээ;
4) зохих фармакопейн стандарт;

5) захиалагч шаардлагатай гэж үзвэл захиалагчийн тэмдэг, код, бүртгэлийн дугаар;
6) баглаа бүр дэх бүтээгдэхүүний орц хэмжээ;
7) хэрэглэх заавар;
8) хадгалалтын онцгой нөхцөл /шаардлага;
9) цувралын дугаар;
10) үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);
11) үйлдвэрийн нэр ба хаяг;
12) бусад шаардлагатай сануулга.

2.2 Гаднах савлагааны дээр дээрх мэдээллийг мөн тэмдэглэсэн байна.

**3. Сав, баглаа боодлын таних тэмдэг**

3.1 Бүх баглаа боодолд доорх мэдээллийг тусгана:
1) захиалагчийн бүртгэлийн дугаар;
2) эмийн ерөнхий нэршил;
3) эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);
4) үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);
5) цувралын дугаар;
6) нэгж боодол дахь тоо хэмжээ ;
7) хадгалалтын тусгай заавар;
8) үйлдвэрийн нэр ба хаяг;
9) бусад шаардлагатай мэдээлэл.

3.2 Боодол бүр нь нэгээс илүүгүй бүтээгдэхүүний цувралыг агуулсан байна.

**4. Онцлог таних тэмдэг**

4.1 Захиалагч нь нийлүүлж буй бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяганд өөрийн таних тэмдгийг тусгуулах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгах замаар нийлүүлэгчид тавьж болно. Түүний загвар болон дэлгэрэнгүй тайлбарыг захиалагч тендер шалгаруулалтын өмнө бэлэн болгосон байх бөгөөд гэрээ байгуулах эрх олгох үед эцэслэн баталгаажуулж нийлүүлэгчид өгнө.

**5. Барааны чанарын баталгааны стандарт**

5.1 Шалгарсан тендерт оролцогч шаардсан тохиолдолд захиалагчид дараах мэдээлэл, баримт бичгийг ирүүлнэ:

1. нийлүүлэгдэж буй барааND хамаарах эмийн нэр төрөл бүрийн тоо хэмжээ, химийн шинжилгээ, ариун чанар, халууруулах чанар, хоруу чанарын болон бусад шинжилгээний талаар ДЭМБ-ын жишиг цувралын болон бүтээгдэхүүний сертификат;
2. аль нэг эсхүл бүх шинжилгээний аргачлал (GMP эсхүл ISO);
3. аль нэгэн онцгойлсон эмийн био-хүртээмж болон/эсхүл био-эквивалентын нотолгоо; Энэ мэдээллийг зөвхөн хатуу нууцлалын доор ирүүлнэ.
4. худалдаанд зориулсан савлалттай холбогдуулж хүчинтэй байх хугацаа дуусах огноо болон тогтвортой чанарыг илэрхийлсэн бусад үзүүлэлтийг

тодорхойлсон үндэслэл
5. барааны дээж.

5.2 Шалгарсан тендерт оролцогч нь захиалагч шаардсан тохиолдолд үйлдвэрлэлт нь GMP-ийн хадгалалтын шаардлагууд болон чанарын хяналтын механизмд нийцэж буй эсэхтэй танилцуулах зорилгоор түүнийг үйлдвэрлэлийн болон агуулахын байранд нэвтрэх боломжоор хангана.

## Эм, эмнэлгийн хэрэгслийг багцлах санамж

Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааны хувьд салбарын онцлог шинж чанараас шалтгаалан зөвхөн бүтээгдэхүүний нэр төрөлд үндэслэсэн стандарт ангиллыг ашиглаж бүтээгдэхүүний багцыг өрсөлдөөнийг хангахуйцаар оновчтой тодорхойлоход хүндрэлтэй байдаг.

Тиймээс эмүүдийг фармакологийн буюу өвчний ангиллаар, эмнэлгийн хэрэгслийг тухайн бараа хэрэглэгдэх нарийн мэргэжлийн тусламжийн төрлөөр багцалж болно. Мөн ижил нэр төрлийн бүтээгдэхүүнийг тэдгээрийг хадгалах хугацаа, хэрэглэх хэмжээ зэргийг сайтар харгалзан багцалж болно. Зайлшгүй шаардлагатай эм худалдан авах ажиллагаанд ашиглаж болох багцын загварыг хавсралтад үзүүллээ. Багц нь аль болох жижиг байх нь зохимжтой.

Эмнэлгийн хэрэгслийг багцлахдаа Эрүүл мэндийн сайдын 2005 оны 325 дугаар тушаалаар баталсан зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг үндэслэн дараах ангиллыг ашиглана. Үүнд:

1) Ороох боох материал
2) Тариур зүү, мэс заслын хутга
3) Оёдлын материал
4) Хамгаалалтын хувцас
5) Катетер, гуурс
6) Рентген
7) Унтуулгын хэрэгсэл
8) Хэт авианы хэрэгсэл
9) Шүд, эрүү нүүрний хэрэгсэл
10) Нүдний хэрэгсэл
11) Чих хамар хоолойн хэрэгсэл
12) Уламжлалт анагаах ухаан
13) Эх барих, эмэгтэйчүүдийн хэрэгсэл
14) Бусад.

Нэг төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг илэрхийлэхэд олон тооны худалдааны нэр болон барааны тэмдгүүд хэрэглэгддэг учир тендер шалгаруулалтын багцыг хийхдээ тухайн эмийн олон улсын нэршлийг ашиглах нь зүйтэй.

Энэ нь мөн өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтыг хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг худалдааны нэрээр ирүүлж шалгарсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчоос худалдааны нэрийн дээд талд том үсгээр, илүү тодоор олон улсын нэршил буюу ерөнхий нэрийг бүх хаяглалт дээр харуулахыг шаардах хэрэгтэй.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

**Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж**

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөлд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох баримт бичиг болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол түүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгаж өгнө.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## ГАРЧИГ


1. Нэр томъёо
2. Үйлчлэх хүрээ
3. Барааны гарал үүслийн улс
4. Стандарт
5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
6. Бүртгэлийн гэрчилгээ
7. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
8. Гүйцэтгэлийн баталгаа
9. Шалгалт болон туршилт
10. Баглаа боодол
11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
12. Даатгал
13. Дагалдах үзэлчилгээ
14. Чанарыг баталгаа
15. Төлбөр
16. Үнэ
17. Захиалгыг өөрчлөх
18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
19. Гэрээний үүргийг шилжүүлэх
20. Гүйцэтгэлийн хугацааг сунгах
21. Алданги оногдуулах
22. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
26. Маргааныг шийдвэрлэх
27. Гэрээнд ашиглах хэл
28. Гэрээнд мөрдөх хууль
29. Мэдэгдэл
30. Татвар болон бусад хураамж

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

**1. Нэр томъёо**

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

(а) “Гэрээ”гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.

(б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.

(в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.

(г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.

(д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.

(е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.

(ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм,эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.

(з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.

(и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.

(к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.

(л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.

(м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил**.**

(н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

**2. Үйлчлэх хүрээ**

2.1 Энэ ерөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.

**3. Барааны гарал үүслийн улс**

3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно

3.2 Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ.

Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

**4. Стандарт**

4.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь Техникийн тодорхойлолтод заагдсан стандартад нийцсэн байна. Тусгайлсан стандарт заагдаагүй тохиолдолд тухайн барааны гарал үүслийн улсын холбогдох стандартад нийцсэн байна. Энэ стандарт нь холбогдох байгууллагын хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбар байна.

**5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах**

5.1 Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.

5.2 Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 5.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээсбусад зорилгоор ашиглахгүй.

5.3 ГЕН-ийн 5.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.

5.4 Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.

**6. Бүртгэлийн гэрчилгээ**

6.1 Гэрээгээр нийлүүлэгдэх эм нь Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн байна.

6.2 Эмэнд бүртгэлийн гэрчилгээ аваагүй бол Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн мэдэгдэлийг эрх бүхий этгээдээс авснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

**7. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**

7.1 Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.

**8. Гүйцэтгэлийн баталгаа**

8.1 Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.

8.2 Нийлүүлэгч гэрээний ажлаа дуусгаж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа

зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 20.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.

8.3 Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар захиалагч хүлээн зөвшөөрөх дараах төрлийн баталгаа байна. Үүнд:

(а) ТендерийнбаримтбичгийнБүлэг VII-дзаасан маягтаар гаргасан банкны баталгаа, эсхүл

(б) Засгийнгазрынбондэсхүл

(в) Засгийнгазрынхүлээнзөвшөөрсөнүнэтцаас

8.4 Нийлүүлэгч гэрээний ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.

**9. Шалгалт болон туршилт**

9.1 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй.

Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

**10. Баглаа боодол**

10.1 Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон гэрэл, чийг зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих буулгах хангалттай төхөөрөмж байхгүй зэргийг харгалзсан байна.

10.2 Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, түүний дотор гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

**11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**

11.1 Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусадбаримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.

11.2 Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/,

FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

**12. Даатгал**

12.1 Үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг гэрээний тусгай нөхцөлд заасан хэлбэрээр даатгуулна.

**13. Дагалдах үйлчилгээ**

13.1 Нийлүүлэгч ГТН-д заасан дагалдах үйлчилгээг гүйцэтгэнэ.

13.2 Хэрэв гэрээний үнэд тусгагдаагүй бол дагалдах үйлчилгээний зардлыг талууд харилцан тохиролцож нийлүүлэгчид төлнө.Энэ зардал нь захиалагчийн бусад гүйцэтгэгчид төлсөн ижил төстэй үйлчилгээний зардлаас хэтрэхгүй байна.

**14. Чанарын баталгаа,**

14.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ үйлдвэрлэгдсэн, өмнө ашиглагдаагүй бөгөөд үйлдвэрлэсэн болон хүчинтэй байх хугацааг хангасан байна. ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, үйлчилгээ нь нийлүүлэгдэх үед 2 жилээс дээш хадгалалтын хугацаатай барааны (5/6) нь өнгөрөөгүй, 2 ба түүнээс доош хадгалалтын хугацаатай барааны хувьд (3/4) нь өнгөрөөгүй болохыг нийлүүлэгч баталгаажуулна.

Мөн гэмтэл согоггүй бөгөөд гэрээний нөхцөлүүд болон техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагаас чанарын шаардлага хангаагүй үндэслэлээр хэрэглээнээс хасагдаагүй, орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.

14.2 Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр нийлүүлэгдсэнээс хойш 3 сарын дотор мэдэгдэнэ. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой барааг үнэ төлбөргүй солино.

**15. Төлбөр**

15.1 Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд дурьдана.

15.2 Нийлүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай бараа нийлүүлэлтийн гүйцэтгэлийг захиалагчид хүргүүлнэ. Уг гүйцэтгэлд нийлүүлсэн бараа үйлчилгээний нэхэмжлэх, ГЕН-ийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

15.3 Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор шуурхай хийнэ.

15.4 Гэрээний дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

**16. Үнэ**

16.1 Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал

болгосон үнийг баримтлана. Гэрээний тусгай нөхцөлийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 17 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.

**17. Захиалгыг өөрчлөх**

17.1 Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг өөрчлөх эрхтэй:

(а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

(б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр

(в) барааг хүргэх газар

(г) нийлүүлэгчийн гүйцэтгэх үйлчилгээ

17.2 Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид өөрчлөлт гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаа болон үнэд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг өөрчилнө. Өөрчлөлттэй холбоотой аливаа гомдол, саналыг захиалгыг өөрчлөх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид гаргана.

**18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**

18.1 ГЕН-ийн 17-т зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.

**19. Гэрээний үүргийг шилжүүлэх**

19.1 Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

**20. Гүйцэтгэлийн хугацаа сунгах**

20.1 Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

20.2 Гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгч бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлэхэд урьдчилан тооцоогүй нөхцөлийн улмаас хугацаа алдах байдал үүссэн бол захиалагчид шалтгаан, үргэлжлэх хугацааг бичгээр шуурхай мэдэгдэнэ. Мэдэгдлийг авсан даруй захиалагч байдлыг үнэлж гүйцэтгэгчийн ажлын хуваарийг сунгах шийдвэрийг алданги оногдуулах эсхүл оногдуулахгүй нөхцөлтэйгээр гаргаж гэрээнд өөрчлөлт оруулна.

20.3 ГЕН-ийн 23-т өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгчийн нийлүүлэлттэй холбоотой үүргийн биелэлтийг хангуулах үүднээс ГЕН-ийн 21-д заасны дагуу алданги оногдуулна. ГЕН-ийн 20.2-т гүйцэтгэлийн хугацааг алданги оногдуулахгүйгээр сунгахаар тохирсон бол энэ заалт хамаарахгүй.

**21. Алданги оногдуулах**

21.1 ГЕН-ийн 23 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч гэрээг ГЕН-ийн 22 дугаар зүйлийн дагуу цуцлах асуудлыг хөндөж болно.

**22. Үүргээ биелүүлээгүйг-ээс гэрээг цуцлах**

22.1 Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад эрх, үйл ажиллагаагаа үл хөндөн нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй:

(а) Нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл 20 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;

(б) Бараа нь гэрээнд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй; эсхүл

(в) ГТН-д заасан хугацаанд тухайн барааны бүртгэлийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг ирүүлээгүй бол.

(г) Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авилгал, залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.

(д) Нийлүүлэгч гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;

22.2 ГЕН-ийн 22.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал**

23.1 ГЕН-ийн 20, 21 ба 22-т заасныг үл харгалзан, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас хугацаа алдсан эсхүл гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх боломжгүй болсон гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаа, алданги, эсхүл үүргээ биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдах хариуцлагыг хүлээхгүй.

23.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч

гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

**24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах**

24.1 Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрх, үйл ажиллагааг хөндөхгүй.

**25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах**

25.1 Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсныг болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.

25.2 Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ:

(а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл

(б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.

**26. Маргааныг шийдвэрлэх**

26.1 Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.

26.2 Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

**27. Гэрээнд ашиглах хэл**

27.1 Гэрээ нь ГТН-д заасан хэл дэр бичигдэнэ. ГЕН-ийн 28-д өөрөөр заагаагүй бол энэ хэл дээр бичигдсэн гэрээний хувилбарыг гэрээг тайлбарлахад мөрдөнө. Гэрээний дагуу талуудын харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

**28. Гэрээнд мөрдөх хууль**

28.1 ГТН-д заагаагүй бол Гэрээ нь Монгол улсын хуулийг мөрдөнө.

**29. Мэдэгдэл**

29.1 Талууд гэрээтэй холбогдсон мэдэгдлийг бичгээр болон факсаар ГТН-д заагдсан хаягаар хүргүүлнэ.

29.2 Мэдэгдэлийг түүний хүргэгдсэн өдөр эсхүл түүнд заасан хүчинтэй хугацааны аль сүүлчийн өдрөөс хүчинтэй гэж үзнэ.

**30. Татвар болон хураамж**

30.1 Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас нийлүүлэх бараанд Монгол улсын гадна оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.

30.2 Дотоодоос нийлүүлэх бараанд захиалагчид нийлүүлэгдэх хүртлэх хугацаанд түүнд оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.

## ДОЛДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

**ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ БЭЛТГЭХ САНАМЖ**

ТШӨХ-ийн нэгэн адил энэ бүлэг нь Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлүүдэд хамаарах тухайлсан мэдээллээр захиалагчийг хангах, түүнд туслах зорилготой бөгөөд худалдан авах ажиллагаа тус бүрт зориулж бэлтгэнэ.

Энэ бүлгийн заалтууд нь Бүлэг VI ГЕН-ийн нэмэлт болох бөгөөд тухайн худалдан авах бараа, салбар болон захиалагчийн тодорхой нөхцөл байдалтай холбогдуулж гэрээний шаардлагуудыг тодорхойлдог.

Гэрээний тусгай нөхцөлүүд нь гэрээний ерөнхий нөхцөлүүдийн нэмэлт хэсэг болно.

Эдгээр нөхцөлүүдийн заалт хоорондоо зөрчилдвөл энэхүү гэрээний тусгай нөхцөлд заасныг баримтална.

Гэрээний тусгай нөхцөл бүрийн өмнө ГЕН-ийн холбогдох заалтын дугаарыг харуулсан болно.

*[Гэрээний тусгай нөхцөлд оруулсан жишиг заалтууд нь түүнийг боловсруулахад зааварчилгаа болгож харуулах зорилготой бөгөөд тухайн худалдан авах ажиллагааны онцлогоос хамааран өөрчлөгдөж болно.]*

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| **1. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)** | |
| ГЕН 1.1 (и) | Захиалагч нь ***[Увс аймгийн Нэгдсэн Эмнэлэг]***. |
| ГЕН 1.1 (о) | Нийлүүлэгч нь ***[ нийлүүлэгчийн нэр]*** |
| ГЕН 1.1 (н) | Байршил: *[**Увс аймгийн төв Улаангом хот 3-багийн нутаг дэвсгэр**]*. |
| ГЕН 1.1 (е) | Ашиглагч байгууллага: ***[Увс аймгийн Нэгдсэн эмнэлэг.*** |
| **2.Үйлчлэх хүрээ (ГЕН-ийн Зүйл 2)** | |
| ГЕН 2 | *[Шаардлагатай бол холбогдох заалтыг оруулах эсхүл: **"ГТН-нь ГЕН-д харшлаагүй тохиолдолд тусгай нөхцөлийг баримтлана"**]* |
| **3.Барааны гарал үүслийн улс (ГЕН-ийн Зүйл 3)** | |
| ГЕН 3 | ***Аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.*** |

| | |
|---|---|
| **4.Стандарт (ГЕН-ийн Зүйл 4)** | |
| ГЕН 4 | ***Нийлүүлэгдэх бараа нь Техникийн тодорхойлолтод заагдсан стандартад нийцсэн байх ба тухайн барааны гарал үүслийн улсын холбогдох стандартад нийцсэн байна. Энэ стандарт нь холбогдох байгууллагын хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбар байна.*** |
| **5.Гэрээний баримт бичгийг хэрэглэх (ГЕН-ийн Зүйл 5)** | |
| ГЕН 5 | ***Гэрээний ерөнхий нөхцөлийг бариментлана*** |
| **6.Барааны бүртгэлийн гэрчилгээ (ГЕН-ийн Зүйл 6)** | |
| ГЕН 6.1 | ***Гэрээгээр нийлүүлэх эм нь Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн байна.*** |
| **7.Оюуны өмчийн эрх (ГЕН-ийн Зүйл 7)** | |
| ГЕН 7 | ***Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.*** |
| **8.Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)** | |
| ГЕН 8.1 | *Шаардлагатай. Гэрээний дүнгийн 5 хувиар бодон гүйцэтгэлийн баталгааг гаргах бөгөөд ГЕН-ийн 8.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авсанаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.* |
| ГЕН 8.4 | |
| **9. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)** | |
| ГЕН 9.1 | ***Захиалгч турших, шалгах эрхтэй. Уг эрхийг зохицуулахдаа ... нийлүүлэлтийн хуваарьт хугацаанд 2 удаа санамсаргүй сонголтийн аргаар, нэр бүхий эм, эмнэлгийн хэрэгсэлийг захиалагчийн сонгосон лабораторид шинжүүлэх бөгөөд үүнтэй холбогдох зардлыг нийлүүлэгч төсөвт тусгаж ирүүлнэ. Тус туршилт, хяналтын зардал нийлүүлэгчийн гэрээний дүнгийн 0,01. хувиас хэтрэхгүй байна.***<br><br>***Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор нийлүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:***<br>***1. Нийлүүлэгч эм, эмнэлэгийн хэрэгслийг нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас 15-аас дээшгүй хоногийн өмнө хөндлөнгийн эрх бүхий лабораторoор дээжийг шинжлүүлж, дүгнэлтийг барааны хамт ирүүлнэ.***<br>***2. Үүнтэй холбогдон гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.***<br>***3. Орон нутгийн иргэд, хэрэглэгчдийн оролцоо бүхий баг нийлүүлж буй эм, эмнэлэгийн хэрэгсэлийг тендерийн баримт бичиг, тендерт заасан шаардлагад нийцэж буй эсэхийг шалгаж, хүлээн авна.***<br>***4. Дүгнэлтийг төлбөрийн гүйцэтгэлд харгалзан үзнэ.*** |
| **10.Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)** | |
| ГЕН 10.2 | ***Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл,*** |

| | |
|---|---|
| | ***тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон гэрэл, чийг зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих буулгах хангалттай төхөөрөмж байхгүй зэргийг харгалзсан байна.*** |
| **11. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН-ийн 3үйл 11)** | |
| ГЕН 11.1 | ***Жишиг заалтууд (CIP нөхцөл)***<br><br>***Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд:***<br><br>Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсан даруй энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.<br><br>Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, ачсан боомт, боомтоос гарах огноо, тээврийн хэрэгслийн нэр, буулгах боомт зэргийг дурдана.<br><br>Нийлүүлэгч дараах баримт бичгийг[5]захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ: Барааг онгоцоор тээвэрлэх тохиолдолд нислэгээс дор хаяж 48 цагийн өмнө тээврийн хэрэгслийн нэр, нислэгийн дугаар, бараа ирэх хугацаа, тээврийн баримтын дугаар зэргийг захиалагчид мэдэгдэнэ.<br><br>Захиалагч мэдэгдлээ факсаар ирүүлж дараах баримт бичгийг захиалагчид, хуулбарыг даатгалын компанид баталгаат шуудангаар хүргүүлнэ. Үүнд:<br><br>2. нийлүүлэгчийн нэхэмжлэхийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувь. Үүнд захиалагчийн нэр, хаяг *[гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих];* гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг зааж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан байна;<br><br>3. Захиалагч *[гаалийн бүрдүүлэлттэй холбогдуулж Захиалагчийн талаар зөв мэдээллийг бичих] болон* гэрээнд заасан бусад мэдэгдэх байгууллагыг дурдаж, Техникийн шаардлагын хуваарьт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон 2 ширхэг хуулбар хувийг болон бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн 2 ширхэг хуулбар хувийн хамт; эсхүл Техникийн шаардлагын хуваарьт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн “Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн” гэсэн тэмдэглэл бүхий 3 хувь баримт<br><br>4. барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт;<br><br>5. Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар;<br><br>6. Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг хуулбар хувь<br><br>7. Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн Шалгалтын гэрчилгээний үндсэн хувь;<br><br>8. Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах |

[5] Инкотермсын аль нөхцөлийг ашиглахаас үүдэн бусад зохих баримт бичгийн нэрийг жагсаана.

| | |
|---|---|
| | ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг<br>9. “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар<br>***Монгол улсын дотроос нийлүүлэх барааны хувьд:***<br>Гүйцэтгэгч бараа хүрэлцэн ирэхэд эсхүл ирэхээс өмнө захиалагчид бичгээр мэдэгдэж дор жагсаасан баримт бичгийг захиалагчид өгсөн байна.Үүнд:<br>1. Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан нийлүүлэгчийн нэхэмжлэхийн хувь; 2 ширхэг үндсэн, 2 ширхэг хуулбар хувь<br>2. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт заасан эцсийн цэгт барааг хүргэхтэй холбоотойгоор төмөр замын, авто замын эсхүл агаарын эсхүл олон төрлийн тээврийн хэрэслийн бараа хүргэсэн баримт, 2 хувь<br>3. Захиалагчийн нэр дээр хийгдсэн даатгалын гэрчилгээний хуулбар<br>4. Барааны баглаа боодол бүрт орсон нэр төрлийг харуулах 4 хувь баглаа боодлын жагсаалт;<br>5. Нийлүүлэгдэж буй бүх нэр төрлийг хамарсан нийлүүлэгчийн барааны гарал үүслийн гэрчилгээний нэг үндсэн хувь<br>6. Шалгалт туршилт шаардсан бол сонгогдсон эрх бүхий байгууллагаас нийлүүлэгчид гаргаж өгсөн шалгалтын гэрчилгээний хуулбар хувь;<br>7. Бараа нийлүүлэх, төлбөр хийхтэй холбогдсон тухайн худалдан авах ажиллагаанд хамаарах бусад шаардлагатай баримт бичиг<br>8. “ДЭМБ-ын олон улсын худалдаанд гарч байгаа эмийн бүтээгдэхүүнд олгох сертификатын схем”-д нийцсэнийг гэрчлэх цувралын гэрчилгээний хуулбар<br>Санамж**:** Нийлүүлэгчийн ирүүлсэн баримт бичиг нь гэрээний шаардлагад нийцэхгүй бол төлбөрийг ГТН-ийн 9 (ГЕН 9)-ийн дагуу хийх шалгалт туршилтын дүнг үндэслэн төлнө. |
| **12.Даатгал (ГЕН-ийн Зүйл 12)** | |
| ГЕН 12.1 | Гэрээ нь CIP үнэд үндэслэсэн тохиолдолд даатгал нь “агуулахаас агуулахад” дайн болон ажил хаялтыг оруулсан “бүх эрсдэл” нөхцөлтэй, CIP үнийн 110 %-ийн дүнтэй байна. |
| **13. Дагалдах үйлчилгээ (ГЕН-ийн Зүйл 13)** | |
